

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ АСУУДЛААР ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНООС  
ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ

2015 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
 хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Дэмбэрэл

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт заасныг баримтлан Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг Төсвийн байнгын хороо 2015 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5-д Нам эвслийн бүлэг нь Байнгын, дэд, түр хорооны бүрэлдэхүүний талаар Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх гэж заасны дагуу Улсын Их Хурал дахь Ардын намын бүлгээс Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбатыг чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Д.Сумьяабазар, Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн нарыг тус дэд хорооны бүрэлдэхүүнд оруулах, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Я.Санжмятавыг тус дэд хорооны бүрэлдэхүүнд оруулах, Улсын Их Хурал дахь бие даагч гишүүдийн зүгээс Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнг тус дэд хорооны бүрэлдэхүүнд оруулах саналыг Улсын Их Хурлын даргатай зөвшилцөхөөр тус тус хүргүүлжээ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэхэд Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн бие даагч гишүүд Улсын Их Хурал дахь цөөнхийн үүргийг хэрэгжүүлэхээ мэдэгдсэн боловч олонхыг бүрдүүлж байгаа гишүүд өөрсдийгөө цөөнх гэж үзсэн тул өөрийн нэрээ татаж авсанаа мэдэгдсэн болно.


Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Улсын Их Хурлын гишүүн Д.Сумьяабазар, Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн, Я.Санжмятав нарыг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд оруулах саналыг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Б.БОЛОР